

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ 05 ДУГААР САРЫН АЖЛЫН ТАЙЛАН

1. Үндсэн үйл ажиллагаа

Газрын үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байна. “Жаргалант сумын Төрийн албан хаагчдыг дэмжих хөгжлийн хөтөлбөр”, “7-р сургууль”, “Их шүтээн цогцолбор ОНӨААТҮГ, “Жаргалант сумын ОНХС” зэрэг байгууллагуудын 2024 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитыг гүйцэтгэж байна

“Жаргалант сумын ЗДТГазар”, “8-р цэцэрлэг”, “Эрдэнэ ус ДТС” ОНӨХК, “Эрдэнэт сан”, “Анхны-Оч ӨЭМТөв”, “Баян-Өндөр сумын ЗДТГ-ын болзошгүй аваарын зардал”-ын 2024 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд санхүүгийн хяналт шалгалтыг дуусгаж тус байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт зөрчил, дүгнэлтийг танилцуулж ажиллалаа.

Аймгийн Засаг даргын 2025.04.30-ний өдрийн А/361 дугаартай захирамжаар 2025.05.09-ний өдөр “Бүх нийтийн мод тарих” ажилд байгууллагын бүх албан хаагчид 60 ширхэг шар хайсыг хуваарьт талбайд тарьлаа.

2025.05.08-ны өдөр Улаанбаатар хотод Олон Улсын Дотоод аудитуудын Институтын Монгол Улс дахь албан ёсны байгууллага болон Монголын Үндэсний Дотоод Аудитуудын Холбооноос зохион байгуулсан “Хиймэл оюуныг дотоод адитад ашиглах нь” сэдэвт сургалтад Газрын дарга Д.Сайзмаа, Дотоод аудитор Т.Ононтуул нар хамрагдлаа.



Аймгийн Засаг даргын төсвийн багцад хамаарах 84 байгууллагын 2025 оны 1 дүгээр улирлын "Шилэн дансны тухай хууль"-ийн хэрэгжилтэд дотоод аудитыг гүйцэтгэлээ. Шилэн дансны хуулийн хэрэгжилт 98%-тай дүгнэгдсэн. Дотоод аудитын тайлан мэдээг холбогдох байгууллагад хүргүүлэн ажиллаж байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг сурталчлан таниулах, мэдээлэл байршуулалтыг сайжруулах зорилгоор “Улс, орон нутгийн төсөвт байгууллагуудын

нягтлан бодогч, мэдээлэл оруулагч нарт 2025.05.28-ны өдөр “Нэгдсэн цахим системд мэдээлэл байршуулалтыг сайжруулах арга зүй”, “Дотоод аудитын үр нөлөө, Засаглал, Эрсдэл, Дотоод хяналтын тогтолцооны төлөвшлийг үнэлэх замаар байнгын сайжруулалтыг төлөвлөх нь арга зүй” сэдэвт цахим сургалтад 62 байгууллагын 96 албан хаагч оролцлоо.



"Ворлд стандарт кансолтинг" ХХК-аар 2025.05.12-13 өдрүүдэд ISO 9001(Чанарын менежментийн тогтолцоо) ба ISO 37001 (Авлигын эсрэг менежментийн тогтолцоо) стандартыг нэгтгэн зөрүүний шинжилгээ хийлгэлээ. Дүн шинжилгээний багийн ахлагч Д.Цэрэнжав ISO 9001, ISO 37001 тэргүүлэх аудитор, багийн гишүүн Э.Халиун SO 9001, ISO 37001 тэргүүлэх аудитор нар ажиллалаа.



2. Сургалт, зөвлөгөөн

- 2025.05.02-ны Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газраас зохион байгуулсан “Хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлѐе-хуулиа мэдье” -Хүүхдийг зодож шийтгэхийг таслан зогсоох олон улсыг өдрийг тохиолдуулан урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажлын хүрээнд “Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль болон холбогдох бусад хууль, журам, хүүхэд хүмүүжлийн эерэг арга” сэдэвт сургалтад Дотоод аудитор Т.Ононтуул, Нягтлан бодогч Р.Долгорсүрэн нар хамрагдлаа.



- 2025.05.08-ны өдөр Насан туршийн суралцахуйн төвтэй хамтран “Байгууллага дахь зөрчлийн сэтгэл зүй”, “Шинэ үеийн хүүхэдтэй харьцах эв дүй” сэдэвт сургалтыг албан хаагчдад зохион байгууллаа.



- 2025.05.14-ний өдөр "Ворлд стандарт кансолтинг" ХХК-ийн хамтын ажиллагааны хүрээнд байгууллагын албан хаагчид "Coaching and feedback" сэдэвт сургалтыг Менежментийн зөвлөх, ISO 9001 стандартын Тэргүүлэх аудитор А.Батгэрэл багшаас авлаа.



- 2025.05.21-ний өдөр Хүний эрхийн Үндэсний Комиссын Орхон аймаг дахь референт Ц.Батзаяатай хамтарсан "Хүний хувийн мэдээлэл хамгаалахад анхаарах асуудал" сэдэвт дотоод сургалтыг зохион байгууллаа.



- 2025.05.29-ний өдөр Татварын газраас зохион байгуулсан "Татварын хууль тогтоомж, эрх зүйн орчин" сэдэвт сургалтад албан хаагчид ажлын байранд хамрагдлаа.
- Монгол Улсын Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ хамтран зохион байгуулж буй "Хамтын хөгжил-Сайн туршлага" сэдэвт зөвлөгөөнд Газрын дарга Д.Сайзмаа, Дотоод аудитор-СХШУАБайцаагч Б.Баасансүрэн нар оролцлоо.



- Төрийн албаны зөвлөлөөс 2025.05.26-30 өдрүүдэд зохион байгуулагдаж байгаа Бүсчилсэн Хөгжил "Төрийн албаны манлайлал" зөвлөгөөнд Нийслэл, 21 аймгийн нутгийн захиргааны байгууллагын туршлагыг тодорхойлох, түгээн дэлгэрүүлэхэд Ахлах мэргэжилтэн Л.Булганцэцэг сургалт, зөвлөгөөнд хамрагдан байгууллагад нэвтрүүлсэн сайн туршлагаа хуваалцлаа.



- Баянгол дүүргийн Засаг даргын дэргэдэх дотоод аудитын албанаас санаачлан Монгол улсын Сангийн яамтай хамтран 2025.05.30-ны өдөр зохион байгуулж байгаа “Үзүүлэх сургалт”-д байгууллагын 4 албан хаагч оролцлоо.



САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР